

2012 ~ 2013

Инчеоны их сургууль Инчеон Солонгос хэлний  
бэлтгэлийн хөтөлбөр  
танилцуулга



## 2013 онд Инcheon Их сургууль нь хотын захиргааны сургуулиас улсын дээд сургууль болж шинэчлэгдэнэ

Инcheon их сургууль нь 12 мянга гаруй бакалавр оюутан ба 1,500 гаруй магистер оюутнуудтайгаар хичээллэж байна. Инcheon их сургууль нь олон улсад нэр хүндээ гаргасан дэлхийн шилдэг их сургууль болохын тулд боловсролын системийн шинэчлэл, шинжилгээ судалгааны хувьд дэлхийд эдийн засгийн чадварлаг байдал, төрийн захиргааны шинэчлэлийн программ зэргийг хамт хэрэгжүүлж чанартай өндөр зэрэглэлийн боловсролыг олон улсын тавцанд гаргах зорилготой. Үүгээрээ дамжин 21-р зууны Солонгосын гол хүчин болох боловсон хүчнийг бий болгох, их дээд сургуулийг дахин шинэчлэх, нөгөө талаас дэлхийн тэргүүний удирдагчийн хэмжээний боловсох хүчнийг бий болгох зорилготой.

Инcheon Их сургуульд суралцсанаар оюун ухаан цогц, хүсэл сонирхол дүүрэн дэлхийн удирдагч нар болцгооно уу.

- Солонгос хэлийг сурж бакалавр, магистарт элсэн суралцах оюутан болон бизнес эрхлэгч, ажилд орох хүсэлтэй гадаадын иргэдэд зориулсан гэх мэт сургалтууд явуулж байна.
- Нэг жилд 4 семестер, 1 өдөрт 4 цаг, 7 хоногт 5 өдөр, 1 семестерт 10 долоо хоног буюу 200 цагийн хичээл үзэх болно.
- Семестер болгон яриа, сонсох, бичих, унших хичээлээс гадна Солонгос хэлний нэгдсэн сургалт болон соёл ёс заншлын хичээлийг хамтад нь суралцах.

- Сургалтын зорилго
  - ▶ Солонгос хэлийг суралцахыг хүссэн гадаад хүмүүст зориулж Солонгос хэл болон соёлын талаар ойлгох чанартай боловсрол эзэмших боломжоор хангах зорилготой.
- Багш боловсон хүчин
  - ▶ Магистарын зэргээс дээш боловсрол эзэмшсэн мэдлэг туршлагатай гадаад хэлний бүрэн мэдлэгтэй Солонгос хэлний багш болон олон талын туршлагатай Солонгосын соёлын өндөр мэдлэгтэй чадварлаг мэргэшсэн багш нараар бүрдүүлсэн баг болон системтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.
- Сургалтын арга барил
  - ▶ Хатуу дүрэмнээс илүүтэйгээр яриа болон сонсгол, унших, бичих гэх мэт сургалтанд гол анхаарлаа хандуулан хичээлээ явуулж буй бөгөөд Солонгосын соёлын хичээлээр дамжуулан Солонгосын нийгэм болон соёлыг ойлгох боломжоор хангаж байна.
- Түвшин тогтоох шалгалт
  - ▶ Түвшин тогтоох шалгалтаар дамжуулан өөрийн хэлний түвшиндээ тааруулан өөрт таарсан ангид аа орох боломжтой бөгөөд 1 ангид 15 оюутан суралцана. / 1-6 р түвшин хүртэл байна /
- Сургалтын түвшинг дүгнэх хэмжээ
  - ▶ Дундаж оноо 60оноо, хичээлийн ирц 80% аас дээш тохиолдолд төгсөх боломжтой.
  - ▶ Яриа, сонсох, бичих, унших дотороос 2 төрлийн дүн нь 60 онооноос доош тохиолдолд дахин шалгалт өгнө.

## Инчеоны Их Сургуулийн бакалавр болон магистрын ангид элсэн суралцах

■ Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын (ТОPIK) 3 болон түүнээс дээш түвшинд тэнцсэн тохиолдолд бакалавр болон магистрын түвшинд элсэн суралцах боломжтой.

- ▶ Инчеоны Их сургуулийн бакалаврын шинэ элсэгчдийг бүртгэх үе: Жил бүрийн 6-р сар 11-р сар
- ▶ Инчеоны Их сургуулийн шилжин суралцагчдыг бүртгэх үе: Жил бүрийн 1-р сар
- ▶ Инчеоны Их сургуулийн магистрын шинэ элсэгчдийг бүртгэх үе: Жил бүрийн 5-р сар 11-р сар

Тус хуваарь сургуулийн нөхцөл байдлаас шалтгаалж жил бүр бага зэрэг өөрчлөгдөж болно.

Инчеоны Их сургуулийн солонгос хэлний бэлтгэлд амжилттай суралцаж чадвал 9 ~ 12 сарын хугацаанд солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын 3-р түвшинд тэнцэх бүрэн боломжтой.

(Албан ёсны ТОPIK-ийн шалгалт : 1 жилд 4 удаа) Вебсайт: <http://www.topik.or.kr> -аас дэлгэрэнгүй харах

### 3

## Үндсэн сургалтын хувиар

жил	улирал	Хичээллэх хугацаа (10 долоо хоног)	Түвшин тогтоох шалгалт	Материал өгөх
Year 2012	хавар	2012.03.09~2012.05.18 (10 долоо хоног)	Гадаадад оршин суугч : 2011.12.10~2012.01.20 Солонгост оршин суугч : 2011.12.10~2012.03.06	2012.03.06
	зун	2012.06.11~2012.08.17 (10 долоо хоног)	Гадаадад оршин суугч : 2012.03.10~2012.04.20 Солонгост оршин суугч : 2012.03.10~2012.06.05	2012.06.05
	намар	2012.09.10~2012.11.16 (10 долоо хоног)	Гадаадад оршин суугч : 2012.06.13~2012.07.23 Солонгост оршин суугч : 2012.06.13~2012.09.04	2012.09.04
	өвөл	2012.12.03~2013.02.08 (10 долоо хоног)	Гадаадад оршин суугч : 2012.09.10~2012.10.22 Солонгост оршин суугч : 2012.09.10~2012.11.27	2012.11.27
Year 2013	хавар	2013.03.18~2013.05.24 (10 долоо хоног)	Гадаадад оршин суугч : 2012.12.10~2013.01.25 Солонгост оршин суугч : 2012.12.10~2013.03.13	2013.03.13
	зун	2013.06.10~2013.08.16 (10 долоо хоног)	Гадаадад оршин суугч : 2013.03.11~2013.04.19 Солонгост оршин суугч : 2013.03.11~2013.06.04	2013.06.04
	намар	2013.09.09~2013.11.15 (10 долоо хоног)	Гадаадад оршин суугч : 2013.06.10~2013.07.19 Солонгост оршин суугч : 2013.06.10~2013.09.03	2013.09.03
	өвөл	2013.12.09~2014.02.14 (10 долоо хоног)	Гадаадад оршин суугч : 2013.09.16~2013.10.25 Солонгост оршин суугч : 2013.09.16~2013.12.03	2013.12.03

※ Дээрх хуваарь нь нөхцөл байдлаас болон өөрчлөгдөж болзошгүй тул шинэ мэдээллийг home page-с харна уу.

※ D-4, F-2, F-4, E-2 гэх мэт визтэй солонгост амьдарч байгаа гадаадын иргэд нэг долоо хоногийн өмнө элсэн хүсэлт гаргах боломжтой.

※ Өмнө нь огт Солонгос хэл үзэж байгаагүй оюутан түвшин тогтоох шалгалт өгөх шаардлагагүй.

※ Хичээллэх хугацаа: 10 долоо хоног / 200 цаг / Хичээллэх өдөр: Даваа ~ Баасан

※ Үдээс өмнөх сургалт / 09:00-13:00 / , үдээс хойш сургалт / 13:30~17:30 / Ихэвчлэн үдээс өмнөх сургалт хичээллэх ба нөхцөл байдлаас шалтгаалж үдээс хойш орох ба бүртгүүлэхдээ хүссэн анги сонгож болно.

※ Жич: Хамгийн багадаа 2 семестрээс дээш суралцах хүсэлтийг гаргах боломжтой.

- ① Суралцах хүсэлт гаргах анкет тогтсон загварын дагуу (сургуулийн веб сайтаас татаж авах) 1хувь.  
(өөрийн танилцуулга, суралцах төлөвлөгөө, төлбөр төлөх төлөвлөгөө)
  - ② Гадаад паспортны хуулбар 2хувь
  - ③ Гадаад паспортны зураг 2 хувь /file .jpg юмуу .gif-ээр/мэйлээр явуулах, [uikorean@incheon.ac.kr](mailto:uikorean@incheon.ac.kr)
  - ④ Ахлах сургууль төгссөн гэрчилгээ болон дүнгийн хуулбарын эх хувь мөн нотариатаар баталгаажуулсан хувь
  - ⑤ Их сургуульд суралцаж байгаа (төгссөн) бол :
    1. Дунд сургуулийн гэрчилгээ + дээд сургуульд суралцаж буй (төгссөн) гэрчилгээний эх хувь болон нотариатаар баталгаажуулсан хувь
    2. Дунд сургуулийн дүнгийн хуулбар + дээд сургуулийн дүнгийн хуулбарын эх хувь болон нотариатаар баталгаажуулсан хувь
  - ⑥ Өөрийн болон эцэг эхийн банкны баталгааны эх хувь (7,000 US\$-с дээш, ойрын 2 сарын доторх тэмдэглэл, банкны салбар, утасны дугаар, хариуцах хүний нэрийг заавал бичсэн байх)
  - ⑦ Өөрийн болон эцэг эхийн ажлын газрын тодорхойлолт, орлогын тодорхойлолт зэрэг баталж болох хөрөнгийн баталгааны бүх бичиг баримтын эх хувь (жилийн орлого, татвар төлсөн баримт, үл хөдлөх хөрөнгө гэх мэт)
- \*Батлан даагч нь тухайн хүнтэй хэрхэн холбогдох тухай тодорхойлолт (төрөл төрөгсдийн лавлагаа, иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хувь)

- ※ Элсэлтийн материал шалгах явцаас шалтгаалан нэмэлт материал шаардаж болзошгүй ба өгсөн материалыг буцааж олгохгүй.
- ※ Солонгосоос элсэгчдийн хувьд D-4, C-3, F-2, F-4, E-2 визтэй хүмүүсийн хувьд тусгайлан лавлахыг хүсье.
- ※ Материал Солонгос эсвэл Англи хэл дээр биш бол заавал орчуулж баталгаажуулсан байх.

- ① Элсэн орох хүсэлт, материалаа өгөх (хүсэлт гаргагч → UIKOREAN)
- ② Материал шалгалт (UIKOREAN)
- ③ Тэнцсэн эсэх мэдэгдэл (UIKOREAN → хүсэлт гаргагч )
- ④ Төлбөр төлөх (хүсэлт гаргагч → UIKOREAN тогтсон данс)
- ⑤ Элсэхийг зөвшөөрсөн бичиг, төлбөр төлсөн бичиг олгох (UIKOREAN → хүсэлт гаргагч )
- ⑥ Визний хүсэлт гаргах (хүсэлт гаргагч → тус улс дахь солонгосын элчин сайдын яам/консулын газар )
- ⑦ Солонгост орж ирэх (хүсэлт гаргагч → солонгос Инчеоны нисэх онгоцны буудал)
- ⑧ Түвшин тогтоох шалгалт өгөх (хүсэлт гаргагч)
- ⑨ Элсэлтийн баяр болон orientation (UIKOREAN хичээлийн танхим)

## Төлбөр төлөх дансны дугаар

Ангилал	Мөнгөний хэмжээ	Тайлбар
Төлбөр	1,100,000вон	Сурах бичгийн үнэ ороогүй
Бүртгэлийн хураамж	50,000 вон	Зөвхөн нэг удаа төлнө

\* 2011оны төлбөрийн түвшин болон 2012 оны сургалтын төлбөрийн мэдээллийг сургуулийн сайтнаас үзнэ үү.  
\* 4семистер (1 жилийн төлбөр) 4,450,000 вон (1,100,000 x 4 семистер+бүртгэлийн хураамж 50,000 )

### Банкны мэдээлэл

\*Банкны нэр : Нунхёб (NONG HYUP BANK) \*Swiftcode : NACFKRSEXXX  
\*Дансны дугаар : 301-0006-9956-71  
\*Хүлээн авагчийн нэр : Univ. of Incheon  
(Инчеоны их сургууль Инчеон хэлний бэлтгэл)  
\*Банкны хаяг : NH Bank Univ. of Incheon Branch  
#119 Academy-ro, Yeonsu-gu, Incheon, 406-772, R.O.Korea

### Бусад зардал :

- ▶ Сурах бичгийн зардал. (өөрөө худалдаж авах)
  - ▶ Гадаад иргэний үнэмлэхний хураамж : 10,000 вон
  - ▶ Онгоцны буудлаас тосч авсны хураамж : 30,000 вон
- (1 долоо хоногийн өмнө тосч авах шаардлагатай эсэхийг мэдэгдэх)  
※ Сургалтын төлбөрөөс бусад төлбөрийг сургуульд ирсний дараа бэлэн мөнгөөр төлж болно.

## Төлбөрийг буцаан олгох

Элсэлтийн хураамж нь буцаж олгогдохгүй, мөнгөн шилжүүлгийн шимтгэлээс үүдэн гарах хүлээн авагчийн

Тохиолдол	Буцаан олгох журам
*Виз гараагүй тохиолдолд *Архаг өвчин болон зайлшгүй хувийн суудал гарсан тохиолдолд *Тус сургуулийн бакалавр магистарт өвшин суралцах тохиолдолд	* Тус семистер эхлэхээс өмнө хүсэлт гаргасан тохиолдолд - 100% буцаан олгоно. * Хичээл эхлээд 1 долоо хоногийн дотор хүсэлт гаргасан тохиолдолд - 70% буцаан олгоно. * Хичээл эхлээд 1 долоо хоног өнгөрсөн хойно хүсэлт гаргасан тохиолдолд – буцаан олгохгүй
*Виз аваад Солонгост орж ирсэн боловч хувийн шалтгаанаас болоод буцах шаардлагатай болсон тохиолдолд	* Тус семистер эхлэхээс өмнө хүсэлт гаргасан тохиолдолд - 90% буцаан олгоно. * Хичээл эхлээд 1 долоо хоногийн дотор хүсэлт гаргасан тохиолдолд - 70% буцаан олгоно. * Хичээл эхлээд 1 долоо хоног өнгөрсөн хойно хүсэлт гаргасан тохиолдолд – буцаан олгохгүй

※ Төлбөр буцаан олгох тохиолдлоос хамаараад суралцахыг зөвшөөрсөн бичгийн эх хувь болон тухайн элчин сайдын яамнаас виз олгохыг татгалзсан бичиг, 4н долоо хоногоос дээш өвчтэй байсан эмнэлэгийн бичиг, тэнцсэн баталгааны бичиг, элсэх төлөвлөгөөний бичиг зэрэг бусад холбогдох бичиг баримтыг хавсарган өгснөөр төлбөрийн мөнгийг буцаан олгох боломжтой болно.

※ Шалгалтанд оруулсан бичиг баримтын зөрчил илрээд виз олгогдоогүй тохиолдолд сургалтын төлбөрийг буцааж олгохгүй.

※ Банкны үйлчилгээний хураамжийг хүлээн авагч төлнө. Bank transaction fees are at recipient's expense.

Байр	<p>*Метрогоор сургууль хүртэл 15~30 минутын зайтай байр (1 болон 2 хүний өрөө гэх мэт) / Сургуулийн дотуур байранд амьдрах боломжгүй.</p> <p>*Сарын дундаж төлбөр 400,000~450,000 вон. Зардлаа төлөхөд хүндрэл үүсч болзошгүй тул 2 –с дээш оюутан хамт амьдарч хувааж төлсөнөөр байрны төлбөрөөс хэмнэх боломжтой. (200,000~250,000 вон)</p> <p>*Сургуулиас оюутнуудын тав тухад нийцүүлэн байр олж өгч тусална.</p>
Гадаад оюутны эрүүл мэндийн даатгал	<p>Солонгост орж ирэхээсээ өмнө гадаадад суралцагч оюутны даатгалд хамрагдаж байж орж ирэх нөхцөлтэй бөгөөд таны хувьд Инчеоны Их сургуулийн хэлний бэлтгэлээс гадаад оюутны даатгалд хамрагдахад туслах болно. Нэг жилийн эрүүл мэндийн даатгалын төлбөр нь 250,000 ~ 400,000 вон (даатгалын төрлөөс хамаарсан зөрүү). Даатгалд хамрагдсан хугацаандаа даатгалын компанийн болзлоос хамааран эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийн дэмжлэг авах боломжтой. (Архаг өвчин болон хүнд өвчин зэрэг нь хамаарахгүй байх магадлалтай). Даатгалд гадаад иргэний үнэмлэх авсны дараа хамрагдах эрхтэй.</p>
Дугуйлангийн үйл ажиллагаа	<p>-Албан ёсны хичээлээс гадуур тус сургуулийн Солонгос оюутантай хамтарч Хослогч хөтөлбөрт оролцох боломжтой / дуудлага засах, Солонгос дуу сурах клуб, Солонгос хэлний харилцан ярианы дугуйлан гэх мэт үдээс хойших үйл ажиллагаанд оролцон Солонгос найзуудтай уулзах болон хэлний чадварыг дээшлүүлэх боломжтой</p>
Тэтгэлэг	<p>Дүнгээр тэргүүлэгчийн тэтгэлэг, Үйл ажиллагаанд идэвхитэй оролцсоны тэтгэлэг</p>
Онцгой хөтөлбөр (Солонгост оршин суугчдад зориулсан богино хугацааны сургалт)	<ul style="list-style-type: none"> <li>■ Солонгос хэлний оройн анги &lt;Яриа голлосон амьд Солонгосхэл, Survival Korean &gt; <ul style="list-style-type: none"> <li>▶ Солонгост оршин сууж байгаа гадаад ажилчдад зориулсан яриа голлосон сургалт (анхан шат, анхан дунд шат, 8 долоо хоногийн сургалт)</li> </ul> </li> <li>■ Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтанд зориулсан &lt;ТОPIK&gt;-ийн анги <ul style="list-style-type: none"> <li>▶ Дээд сургуульд элсэн суралцахын тулд солонгос хэлний шалгалтын 3-р түвшинд тэнцэхүйцээр дунд гүнзгий түвшний сургалт (дунд гүнзгий шатны сургалт 4 долоо хоног)</li> </ul> </li> <li>■ Солонгос хэлний итгэмжлэгдсэн боловсрол (Аж ахуй нэгж болон багаараа хүсэлт гаргах боломжтой) (анхан шатны анги – гүнзгий шатны ангийн сургалт) <ul style="list-style-type: none"> <li>▶ Аж ахуй нэгж албан байгууллагаас хүсэлт гаргаснаар зөв бичгийн онцгой боловсролыг эзэмшүүлэх богино хугацааны солонгос хэлний сургалт</li> </ul> </li> <li>■ Солонгос хэлний багш бэлтгэх хөтөлбөр <ul style="list-style-type: none"> <li>▶ Солонгос хэлний хичээл заах багш бэлтгэх зорилгоор онлайн болон оплайн (online and offline) сургалтанд хамрагдан солонгос хэлний багшийн 3-р түвшингийн үнэмлэх авах боломжтой чухал хөтөлбөрөөр 8 долоо хоногийн сургалт.</li> </ul> </li> </ul>

Инчеон их сургууль нь Солонгос улсын нийслэл Сөүлийн баруун зүгт орших Инчеон хотод байрлаж байна. Инчеон хот нь 2саа 700мянган хүн амтай Солонгос улсын 3 дугаарт орох том хот бөгөөд Инчеон олон улсын нисэх буудал болон Инчеон олон улсын усан боомт байрлаж байгаагаараа гадаад харилцаа холбоо сайтай юм. Түүхийн хувьд Инчеон хот нь 20-р зууны эхнээс эхлээд Солонгос улсын гол гарцын үүргийг гүйцэтгэж ирсэн бөгөөд 21-р зуунд дэлхийд хэмжээ хүрээгээрээ болон тэргүүний дэд бүтэц, байр байгууламжтайгаар Инчеон олон улсын нисэх буудлыг нэвтрүүлснээрээ зүүн азийн төв хот болон ирсэн болно.



**인천대학교 인천한국어학당 Univ. of Incheon**

**Incheon Institute for Korean Language Studies (UIKOREAN)**

#119 Academy-ro, Yeonsu-gu, Incheon, 406-772, R.O.Korea

Phone : (82+32)835-9581~9582 Fax : (82+32) 835-0735

Web Site : <http://iikls.incheon.ac.kr> E-mail, MSN : [uikorean@incheon.ac.kr](mailto:uikorean@incheon.ac.kr)

